



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураагуй тайлан

Аудитын код: АРА-2024/63-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)  
Архангай аймаг  
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn  
Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn  
Гэрээгээр аудит гүйцэтгэсэн:  
Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК  
Захирал С.Оргил  
Утас: 99197346  
Цахим хаяг:  
shinjlenmagadlahui.ezsh.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.02.25 № 79  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ЧУЛУУТ СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Н.БУЖИНЛХАМ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Чулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Чулуут сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд 114,451.9 мянган төгрөгийн бараа материал, 2,983.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан ба БШУЯ-аас хандив тусламжаар 2,983.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

### Аудитын гол асуудал

Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 26.7 хувиар өссөн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 үндсэн зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг БШУГ-аас 85,7% хувьтай үнэлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	64,643,273.45	194,381,197.84
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,682,746.40	130,558,704.59
312	Банканд байгаа бэлэн мөнгө	1,682,746.40	130,558,704.59
31211	Төрийн сангийн харилцах	1,682,746.40	130,558,704.59
35	БАРАА МАТЕРИАЛ	62,960,527.05	63,822,493.25
351	Түүхий эд материал	1,321,000	1,321,000
35130	Эм боох материал	1,321,000	1,321,000
354	Хангамжийн материал	61,639,527.05	62,501,493.25
35410	Бичиг хэргийн материал	540,500	78,500
35420	Аж ахуйн материал	61,099,027.05	59,412,063.25
35460	Хүнсний материал		3,010,930
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	587,809,514.32	566,007,154.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	587,809,514.32	566,007,154.80
392	Биет хөрөнгө	576,829,514.32	555,027,154.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	583,536,692.53	583,536,692.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	-52,412,748.84	-62,439,439.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,724,571.20	39,370,571.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,036,432.59	-23,830,158.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,783,969.20	25,016,279.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,168,295	-18,421,934.16
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,639,680	21,639,680
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,819,839.96	-14,426,453.28
39217	Ном	4,581,917.78	4,581,917.78
393	Биет бус хөрөнгө	10,980,000.00	10,980,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,980,000.00	10,980,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	652,452,787.77	760,388,352.64
	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,960,430.00	261,294.00
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,960,430.00	261,294.00
	Өглөг	2,960,430.00	261,294.00
	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,960,430.00	261,294.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	649,492,357.77	760,127,058.64
51	Засгийн газрын хувь оролцоо	649,492,357.77	760,127,058.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	52,085,034.10	52,085,034.10
51101	Өмч: - төрийн	52,085,034.10	52,085,034.10
512	Хуримтлагдсан үр дүн	534,911,137.56	645,545,838.43
51210	Өмнөх үеийн үр дүн	534,911,137.56	534,911,137.56
51220	Тайлант үеийн үр дүн	534,911,137.56	110,634,700.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	62,496,186.11	62,496,186.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	652,452,787.77	760,388,352.64

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

**Архангай аймгийн Чулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,223,209,247.53	779,417,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	682,178,647.53	-
120	Нийтлэг татварын бус орлого	682,178,647.53	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	607,975,643.17	2,983,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	74,203,004.36	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	541,030,600.00	776,434,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	485,421,900.00	740,706,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	485,421,900.00	740,706,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	7,814,680.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,814,680.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,608,700.00	35,727,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,608,700.00	35,727,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	576,737,796.57	668,782,999.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	576,737,796.57	668,782,999.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	570,110,586.57	668,693,020.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,735,023.81	459,023,941.81
210101	Үндсэн цалин	274,590,231.81	335,543,802.81
210102	Нэмэгдэл	72,043,426.00	97,287,662.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	27,101,366.00	26,192,477.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,428,726.00	57,411,719.00
210201	Тэтгэврийн даатгал	32,568,220.19	38,990,560.43
210202	Тэтгэмжийн даатгал	3,766,706.12	4,587,124.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,122,832.68	4,048,693.19
210204	Ажилгүйдлийн даатгал	710,430.57	877,557.46
210205	Эрүүл мэндийн даатгал	7,260,537.04	8,907,783.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,052,830.00	32,984,185.00
210301	Гэрэл, цахилгаан	5,948,170.00	7,820,746.00
210302	Түлш, халаалт	24,754,660.00	24,320,635.00
210303	Цэвэр, бохир ус	350,000.00	842,804.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,959,008.31	7,463,263.80
210408	Бараа материал акталсны зардал	15,959,008.31	7,463,263.00
2105	Нормативт зардал	64,913,669.00	65,642,351.00
210502	Хоол,хүнс	64,913,669.00	65,642,351.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,582,300.00	1,144,000.00
210604	Урсгал засвар	1,582,300.00	1,144,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,258,000.00	1,144,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,258,000.00	1,144,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,181,028.85	43,909,159.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,657,200.00	15,068,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,057,700.00	4,054,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,466,128.85	24,785,859.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,627,210.00	89,979.00

**Архангай аймгийн Чулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2132	Бусад урсгал шилжүүлэг	5,173,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,173,400.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,453,810.00	89,979.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,453,810.00	89,979.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	646,471,450.96	110,634,700.87
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	646,471,450.96	110,634,700.87

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	541,030,600.00	776,434,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	541,030,600.00	776,434,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	485,421,900.00	740,706,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	485,421,900.00	740,706,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,608,700.00	35,727,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,608,700.00	35,727,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	538,047,853.60	647,558,241.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	538,047,853.60	647,558,241.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531,420,643.60	647,468,262.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	372,223,018.60	458,038,758.00
210101	Үндсэн цалин	280,232,140.00	314,673,821.00
210102	Нэмэгдэл	74,332,821.60	115,361,551.00
210104	Урамшуулал	17,658,057.00	28,003,386.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,919,825.00	58,396,902.81
210201	Тэтгэврийн даатгал	31,246,831.21	39,541,808.60
210202	Тэтгэмжийн даатгал	3,676,138.65	4,675,055.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,862,560.03	4,114,338.51
210204	Ажилгүйдлийн даатгал	810,627.63	917,635.70
210205	Эрүүл мэндийн даатгал	7,323,667.48	9,148,064.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,583,900.00	34,493,921.00
210301	Гэрэл, цахилгаан	6,889,270.00	7,820,746.00
210302	Түлш, халаалт	21,344,630.00	26,542,971.00
210303	Цэвэр, бохир ус	350,000.00	130,204.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	63,583,500.00	68,718,081.00
210502	Хоол, хүнс	63,583,500.00	68,718,081.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,144,000.00	1,144,000.00
210604	Урсгал засвар	1,144,000.00	1,144,000.00
2107	Томиллолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,258,000.00	1,114,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,258,000.00	1,114,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,708,400.00	25,562,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,213,000.00	22,002,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,495,400.00	3,560,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,627,210.00	89,979.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,173,400.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,173,400.00	

**Архангай аймгийн Чулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,453,810.00	89,979.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,453,810.00	89,979.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,982,746.40	128,875,958.19
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	1,300,000.00	
	Дотоод эх үүсвэрээр	1,300,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,300,000.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,300,000.00	
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,682,746.40	128,875,958.19
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,682,746.40
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		130,558,704.59

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,085,034.10	62,496,186.11	562,009,100.93	676,590,321.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-673,569,414.33	-673,569,414.33
C07	Тайлант үеийн үр дүн			646,471,450.96	646,471,450.96
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,085,034.10	62,496,186.11	534,911,137.56	649,492,357.77
D08	Тайлант үеийн үр дүн			110,634,700.87	110,634,700.87
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,085,034.10	62,496,186.11	645,545,838.43	760,127,058.64

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	778,116,900.00	647,468,262.81	130,648,637.19	82.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	778,116,900.00	647,468,262.81	130,648,637.19	82.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	778,116,900.00	647,468,262.81	130,648,637.19	82.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	559,001,700.00	458,038,758.00	100,962,942.00	81.94
210101	Үндсэн цалин	367,194,600.00	314,673,821.00	52,520,779.00	85.70
210102	Нэмэгдэл	174,053,900.00	115,361,551.00	58,692,349.00	66.28
210104	Урамшуулал	17,753,200.00	28,003,386.00	-10,250,186.00	157.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,074,800.00	58,396,902.81	11,677,897.019	83.34
210201	Тэтгэврийн даатгал	47,715,100.00	39,541,808.60	8,174,291.40	82.37

**Архангай аймгийн Чулуут сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210202	Тэтгэмжийн даатгал	5,590,000.00	4,675,055.40	914,944.60	83.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,471,800.00	4,114,339.51	357,461.41	92.01
210204	Ажилгүйдлийн даатгал	1,117,500.00	917,635.70	199,864.30	82.12
210205	Эрүүл мэндийн даатгал	11,180,400.00	9,148,064.60	2,332,335.40	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,583,900.00	34,493,921.00	89,979.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	9,746,900.00	7,820,746.00	1,926,154.00	
210302	Түлш, халаалт	24,409,200.00	26,542,971.00	-2,133,771.00	
210303	Цэвэр, бохир ус	427,800.00	130,204.00	297,596.00	
2105	Нормативт зардал	86,440,700.00	68,718,081.00	17,722,619.00	79.50
210502	Хоол, хүнс	86,440,700.00	68,718,081.00	17,722,619.00	79.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,144,000.00	1,144,000.00	0	
210604	Урсгал засвар	1,144,000.00	1,144,000.00	0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,186,700.00	1,114,400.00	72,300.00	93.91
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,186,700.00	1,114,400.00	72,300.00	93.91
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,685,100.00	25,562,200.00	122,900.00	99.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,125,000.00	22,002,100.00	122,900.00	99.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,560,100.00	3,560,100.00	0.00	100
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>778,116,900.00</b>	<b>778,026,921.00</b>	<b>89,979.00</b>	<b>99.97</b>
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>740,706,300.00</b>	<b>740,706,300.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	740,706,300.00	740,706,300.00	0.00	100.00
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>35,727,900.00</b>	<b>35,637,921.00</b>	<b>89,979.00</b>	<b>99.75</b>
132001	Орон нутгийн төсвөөс	35,727,900.00	35,637,921.00	89,979.00	99.75
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,682,700.00</b>	<b>1,682,700.00</b>	<b>0.00</b>	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,682,700.00	1,682,700.00	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,682,700.00	-1,682,746.40	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	130,558,704.59	-130,558,704.59	
5	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>29.5</b>	<b>29.5</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
6	Удирдах ажилтан	1	1		
7	Гүйцэтгэх ажилтан	13	13		
8	Үйлчлэх ажилтан	15.5	15.5		
10	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>250.00</b>	<b>250.00</b>		
15	Төрийн өмчит СӨБ байгууллага	1	1		

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудал илэрсэн нь тогтоосон материаллаг байдлын дүн 4,532.2 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлын хүрээнд илэрсэн 3029.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн болно. /4.4.2 дахь хэсгээс үзэх/

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллийг хугацаа хоцроосон	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авалт хийхдээ шууд гэрээ байгуулан ажилласан.	1	3,029.7					1	3,029.7
Дүн	1	3,029.7					1	3,029.7
Нийт дүн	2	3,029.7					2	3,029.7